

# **ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ**

*ДХИС-ОБС-ийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн дэд  
профессор, ахмад Л.Булганхангай*

## **Хураангуй**

Уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын байдлаас үүдэн гал түймрийн эрсдэл, давтамж, нэмэгдэхийн зэрэгцээ өртөх хохирол өсөж байдаг бол нөгөө талаас гал түймэр ан, амьтан, ойн сан, онгон зэрлэг байгаль, ногоон байгууламж, хадлан бэлчээр зэргийг устгах, түүнээс ялгарах бүтээгдэхүүн нь хүлэмжийн хийг нэмэгдүүлэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг.

Монгол орны 11.8 хувийг ойн сан эзэлдэг ба ой, хээрийн гал түймрийн судалгаанаас үзэхэд 21-р зууны эхний 10 жил (2001-2010)-д гарсан ой, хээрийн гал түймрээс сүүлийн 10 жил (2011-2020)-д ой, хээрийн гал түймрийн тоо 12 хувиар өссөн, гал түймрийн улмаас учирсан хохирол 27 хувиар, өртсөн талбай 7 нэмэгдсэн байгаа нь Монгол орны агаарын дундаж температур сүүлийн 80 гаруй жилд 2.25 хэмээр нэмэгдсэнтэй шууд хамааралтай юм.

## **Түлхүүр үг**

Ой, хээрийн гал түймэр, Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, сайн дурын хэсгийн чадавх, эрхзүйн орчин.

## **Оршил**

Монгол Улс нь Азийн эх газрын төв хэсэгт орших бөгөөд баруунаас зүүн зах хүртэл 2392 км, хамгийн хойд цэгээс өмнөд цэг хүртэл 1259 км нийт 1.565.000 км квадрат газар нутаг дэвсгэртэй. Манай орны нутаг дэвсгэрийн 55.3 хувь нь ой, хээрийн түймэр гарч болзошгүй бүсэд багтдаг. Ялангуяа, түүний дотроос ой бүхий нутгуудын ихэнх хэсэг нь ойн түймрийн аюулд өртөх магадлал өндөр бүсэд оршиж байна. Ой бүхий нутгийн 98,52 хувь нь гал түймрийн эрсдэлийн I ба II ангилалд багтдаг<sup>8</sup>.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол орны хуурайшилтын зэрэг нэмэгдэж, ой, хээрийн гал түймэр гарах, асар хурдтай тархах таатай нөхцөл бүрдүүлж байна. нэгэнт ассан, олон мянган га талбайг хамарсан түймрийг унтраахад хангалттай хүн хүчний дутагдалтай учир эхний

---

<sup>8</sup> Гамшиг судлалын үндэсний хүрээлэн “Монгол орны ой, хээрийн түймрийн урьдчилсан таамаглал” 2022он

дуудлагаар очсон бүлэг түймрийн тархалтыг зогсоох, түймэр тархан дэлгэрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ой, хээрийн гал түймрийг шуурхай унтраах бүлэг орон нутгийн газар зүйн байршлаас хамаарч хол замыг туулан, хугацаа алдаж түймрийн голомтод очдог, сайн дурынхны гал түймэртэй тэмцэх чадавх сул зэрэг шалтгааны улмаас гал түймрийн тархалт, хохирлын хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд дээрх үзүүлэлтүүд цаашид улам өсөх магадлал өндөр байна. Энэ нь монгол хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, ан, амьтан хомсдож, хүрээлэн буй орчин доройтож, уур амьсгалын өөрчлөлт нэмэгдэхэд ихээхэн нөлөөлж байна.

Хорин нэгдүгээр зууны эхний 10 жил (2001-2010 - 1498)-д гарсан ой, хээрийн гал түймрээс сүүлийн 10 жил (2011-2020 - 1984)-д ой, хээрийн гал түймрийн тоо 24,4 хувиар өссөн, гал түймрийн улмаас учирсан хохирол 27 хувиар нэмэгдсэн байна.

Монгол улсад сүүлийн 5 жилд буюу 2018-2022 онд нийт 583 удаа, жилд дунджаар 117 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч Онцгой байдлын байгууллагаас 8727 алба хаагч, хил хамгаалах байгууллагаас 1447 алба хаагч, сум орон нутгаас 15974 иргэн, нийт 4069 автомашин, техниктэйгээр ажиллаж унтраасан ба түймрийн улмаас 536 мянган га талбай түймэрт өртөж, түймрийн улмаас байгаль экологид 16 тэрбум, эд материалын 119 сая, түймрийг унтраахад 218 сая төгрөгийн зардал гарсан.

Цаг уур орчны шинжилгээний газрын MODIS хиймэл дагуулын мэдээллийн систем [www.icc.mn/](http://www.icc.mn/), НАСА-ийн [firms.modaps.eosdis.nasa.gov/map](http://firms.modaps.eosdis.nasa.gov/map) системийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Ой, хээрийн гал түймрийг эрт илрүүлэх, түймрийн нөхцөл байдлыг үнэлэх, хяналт тавих, түймэрт өртсөн ой, хээрийн талбай, түймрийн хохирлыг тодорхойлоход ашиглаж байна.

Алслагдсан, автомашинтай хүрэлцэн очих боломжгүй газар гарсан түймрийг унтраах бараг боломжгүй, цаг хугацаа алдаж, түймрийн тархалт нэмэгддэг тул эдгээр газруудад зөвхөн сансрын мэдээллийн системийг ашиглан түймрийн тархалтыг хянах ажлыг хийж байна.

Галын аюулгүй байдлын тухай хууль 2015 онд шинэчлэгдсэнээр Монгол улсад гал түймэртэй тэмцэх сайн дурын ажиллагааны эхлэл тавигдаж, хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ыг мөн онд батлуулснаар орон нутагт Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг байгуулж эхэлсэн. Төв, орон нутгийн Засаг даргын захирамжаар улсын хэмжээнд 20 аймгийн 287 сум, нийслэлийн 8 дүүрэгт нийт 295 гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулагдан гал

түймэр унтраах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.


### Судалгааны материал, аргазүй:

Улсын хэмжээнд 2023 онд Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл Баян-Өлгий, Увс, Хэнтий, Завхан, Говьсүмбэр, Өвөрхангай зэрэг 14 аймгийн 42 суманд 101 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн. Ой, хээрийн гал түймрийн дуудлагын тоог 2022 оны мөн үетэй харьцуулахад **43%-иар** буурсан.

Дээрх түймэрт 10 хүн түлэгдэж, 40 гэр, байшин (сууц), 71 хашаа (саравч), 9 автомашин, 7,931 мал, 148 ан амьтан, ойн 1,296 га, хээрийн 3,079,274га, нийт 3,080,570га талбай өртөж байгаль экологид 16,786,348,567 төгрөг, эд материалын 6,247,933,518 төгрөг, гал түймрийг унтраахад 103,711,746 төгрөг зарцуулж, нийт 23,164,993,831төгрөгийн хохирол учирсан байна.


Ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 1286 алба хаагч, 125 автомашин, Хил хамгаалах байгууллагын 399 алба хаагч, 49 автомашин, 2 морь, Зэвсэгт хүчний 52 алба хаагч, 3 автомашин, 2 нисдэг тэрэг, Цагдаагийн байгууллагын алба 10 хаагч, 3 автомашин, орон нутгаас 3142 иргэн, 492 автомашин, 1 трактор, 91 мотоцикл, 18 морь, нийт 4889 хүн, 669 автомашин, 3 нисдэг тэрэг, 1 трактор, 91 мотоцикл, 20 морьтой ажилласан.

Сүүлийн 10 жилүүдийн судалгаанаас үзэхэд ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцсон нийт хүн хүч, хэрэгслийн 27,8 хувийг Онцгой байдлын алба хаагчид, 64,4 хувийг орон нутгийн Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гишүүд, иргэд эзэлж байна.



Улсын хэмжээнд 295 гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт 3368 хүний бүрэлдэхүүнтэй, 65 ширхэг гал түймэр унтраах зориулалтын

автомашинтай үйл ажиллагаа явуулж байгаагаас үзэхэд гал түймэр унтраах автомашин, багаж хэрэгслийн хангалт 22 хувьтай буюу дутмаг байна.



Энэ гал түймэр унтраах ажиллагаанд оролцож буй сайн дурын гишүүдийн үүрэг гүйцэтгэлт, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нь харагдаж байна.

Онцгой байдлын байгууллагаас алслагдсан орон нутагт гарсан ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд тухайн орон нутгийн Гал түймэр унтраах сайн дурын хэсэг анхны дуудлагаар гарч ажилладаг бөгөөд тэдгээрийн гал түймэртэй тэмцэх чадавх муугаас шалтгаалж унтраах ажиллагаа удаашрах, тархалт, хамрах хэмжээ, хохирол нэмэгдэх зэрэг хүндрэлүүд гардаг нь практикаас харагддаг.

Мөн зарим тохиолдолд орон нутгийн сайн дурын хэсэг дуудлагаар гарахгүй байх, удаан хугацааны дараа гарах зэрэг асуудал үүсдэг нь эрх зүйн орчин дутмаг байдлаас бий болж байгаа бөгөөд Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс гаргасан судалгаанаас<sup>9</sup> харагддаг.

Монгол улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам” Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-аар үйл ажиллагааг зохицуулж байгаа хэдий ч дээрх журмуудад сайн дурын хэсгийн ажилтны нийгмийн баталгаа, санхүүжилт урамшуулал зэргийн талаар тусгасан боловч орон нутгийн төсөвт санхүүжилт суудаггүй гэх үндэслэлээр чадавхыг сайжруулах болон урамшуулал олгогддоггүй байна.

Судалгааны үр дүн:

<sup>9</sup> Гамшиг судлалын үндэсний хүрээлэн “Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа” 2020он

Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж гишүүдийн нийгмийн баталгаа, гал түймэртэй тэмцэх хүч хэрэгслийг нарийвчлан тусгах зэргээр шинэчлэн боловсруулж Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс батлуулснаар, чадавхыг сайжруулах, нийгмийн баталгааг хангах санхүүгийн зохицуулалт хийгдэх боломж үүснэ.

Дэлхийн улс орнуудын гал түймэртэй тэмцэх байгууллагын сайн дурын хүчний дундаж нийт хүн амын 2 орчим хувьтай байдаг бол монгол улсын хувьд 0,09 орчим хувь байгааг дэлхийн жишигт хүргэх шаардлага байгаа тул иргэдийг сайн дураар эвлэлдэн нэгдэхэд уриалах сурталчлах ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

Сайн дурын хэсгийн гишүүдийг богино хугацааны мэргэжлийн сургалтад суулгах асуудлыг Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтран зохион байгуулах, сургалтын шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах зохицуулалтыг эрх зүйн орчин сайжруулах замаар тусгана.

Хэлэлцүүлэг:

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14.3. “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажилтанд тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална” гэж заасныг Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журмыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, сайн дурын хэсгийн гишүүнд цалин, урамшуулал, шагнал, тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална гэж өөрчлөх.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36.4-т “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасныг үндэслэн Монгол улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-тай нийцүүлэн Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журмыг нэн тэргүүнд шинэчлэн боловсруулж батлуулах.

### **Ашигласан материал**

1. Байгаль орчны төлөв байдлын тайлан. Ойн газар, 2019-2020
2. Гамшиг судлалын үндэсний хүрээлэн “Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа” 2020он
3. Гамшиг судлалын үндэсний хүрээлэн “Монгол орны ой, хээрийн түймрийн урьдчилсан таамаглал” 2022он
4. Байгаль экологийн үр дүн ба ойн түймэр. Малко Н.А. Ходикова Н.А.